

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/006/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Сүхбаатар сум

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх

Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Отгонбаяр

Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Аудитор: О.Анхбаяр

Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.АРИУНЖАРГАЛ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.23 № СА-2026/006/НА-СА-ТТЗ

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар болон санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд илэрсэн дараах зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”, 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1.2 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Батлагдсан төсвийг зориулалт бусаар, хөтөлбөр, зориулалт, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **10,909.3** мянган төгрөгийн,
- Орон нутгийн төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөөг **132,719.5** мянган төгрөгөөр тасалсан,
- Тайлант онд ЗДНХ-өөс гадаад паспортын төхөөрөмж худалдан авах зардалд **957.0** мянган төгрөгийг зарцуулсан,
- Тайлант онд ЗДТГ нь “Мөнгөн өвөл-2025”, “Марш тактик-2025” зэрэг уралдаан тэмцээн зохион байгуулж **2,870.0** мянган төгрөгийг байгууллагын үндсэн болон баг, хорооны үйл ажиллагааны зардлаас зарцуулсан,

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Сумын ИТХ-ын “Алтанбулаг сумын 2025 оны тодотгосон төсөв батлах тухай” 44 дүгээр тогтоолоор тайлант онд 1,159,199.3 мянган төгрөгийн татварын орлого, 163,092.9 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **1,322,292.2** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **1,189,572.7** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 10.0 хувиар тасалсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төсвийн зарцуулах эрх тавигдаагүйгээс шалтгаалан байгууллагад төлөх өглөг 99,176.0 мянган төгрөгийн, хувь хүнд төлөх 4,142.6 мянган төгрөгийн зэрэг нийт **103,318.6** мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна.

Бусад асуудлын хэсэг

Алтанбулаг сумын Засаг дарга нь тайлант онд 6 зорилт, 119 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, **89.0** хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ


 /мянган төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		589,925.9	639,750.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		463,124.9	525,502.7
33	АВЛАГА		54,144.0	36,484.6
35	БАРАА МАТЕРИАЛ		72,657.0	77,763.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		6,679,137.7	7,311,278.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		6,679,137.7	7,311,278.7
39200	Биет хөрөнгө		6,528,048.2	7,096,104.8
39300	Биет бус хөрөнгө		151,089.5	215,173.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		7,269,063.6	7,951,029.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,965.2	102,477.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		9,965.2	102,477.4
41300	Өглөг		9,965.2	102,477.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,259,098.4	7,848,551.7
51	Засгийн газрын хувь оролцоо		7,259,098.4	7,848,551.7
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,269,358.0	1,269,358.0
51200	Хуримтлагдсан үр дүн		5,098,992.2	5,688,445.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		890,748.2	890,748.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		7,269,063.6	7,951,029.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		7,214,973.7	3,938,887.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,039,720.7	1,107,308.3
110	Орлогын албан татвар		808,597.5	804,864.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		878,862.3	890,889.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(70,264.8)	(86,025.6)
113	Хөрөнгийн албан татвар		95,698.0	81,421.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		135,425.2	221,022.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		4,844,034.3	2,831,579.3
120	Нийтлэг татварын бус орлого		4,844,034.3	1,398,771.0
122	Тусламжийн орлого		0.0	811,648.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		0.0	621,160.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,331,218.7	0.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		2,122,819.4	2,651,975.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,122,819.4	2,651,975.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,085,617.4	2,618,313.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		878,530.3	932,044.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		108,566.4	124,834.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		526,864.7	525,113.1
2104	Хангамж, бараа материалын зардал		37,507.1	59,537.3
2105	Нормативт зардал		2,942.6	264.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		38,518.9	92,994.8

2107	Томилолт, зочны зардал		7,221.7	7,515.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		113,629.2	142,828.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		371,836.5	733,180.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		37,202.0	33,662.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		5,092,154.4	1,286,911.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		519,694.9	697,458.5
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(519,694.9)	(697,458.5)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		4,572,459.5	589,453.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,269,358.1	890,748.2	526,532.7	2,686,638.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,269,358.1	890,748.2	526,532.7	2,686,638.9
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	4,572,459.5	4,572,459.5
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,269,358.1	890,748.2	5,098,992.2	7,259,098.4
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,269,358.1	890,748.2	5,098,992.2	7,259,098.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,269,358.1	890,748.2	5,098,992.2	7,259,098.4
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	589,453.3	589,453.3
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,269,358.1	890,748.2	5,688,445.4	7,848,551.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,565,640.6	2,645,747.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,039,720.7	1,107,308.3
110	Орлогын албан татвар	808,597.5	804,864.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	878,862.3	890,889.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(70,264.8)	(86,025.6)
113	Хөрөнгийн албан татвар	95,698.0	81,421.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	135,425.2	221,022.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	27,617.6	67,730.6
1181	Газрын төлбөр	34,569.2	64,208.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	73,238.4	89,083.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	189,547.2	1,538,439.1
120	Нийтлэг татварын бус орлого	189,547.2	105,630.8
122	Тусламжийн орлого	0.0	811,648.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	621,160.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,336,372.7	0.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,770,355.5	1,966,441.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,770,355.5	1,966,441.3

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,733,153.5	1,939,478.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	869,201.3	932,716.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,599.7	124,834.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	526,864.6	525,113.1
2104	Хангамж, бараа материалын зардал	34,992.0	58,272.3
2105	Нормативт зардал	227.4	264.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,102.9	90,794.8
2107	Томилолт, зочны зардал	7,221.7	7,515.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	88,158.9	140,977.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,785.0	58,990.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,202.0	26,962.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	795,285.2	679,306.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	571,464.9	616,928.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	571,464.9	616,928.3
2200	Дотоод эх үүсвэрээр	571,464.9	616,928.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(571,464.9)	(616,928.3)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	223,820.3	62,377.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	239,304.6	463,124.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	463,124.9	525,502.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/


Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,708,878.6	2,598,525.5	110,353.1	95.9
11	Татварын орлого	1,159,199.3	1,107,308.3	51,891.0	95.5
110	Орлогын албан татвар	829,437.7	804,864.2	24,573.5	97.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	899,737.7	890,889.7	8,848.0	99.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(70,300.0)	(86,025.6)	15,725.6	122.4
113	Хөрөнгийн албан татвар	94,191.7	81,421.2	12,770.5	86.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	235,569.9	221,022.9	14,547.0	93.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	80,112.7	67,730.6	12,382.1	84.5
1181	Газрын төлбөр	38,000.0	64,208.4	(26,208.4)	169.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	117,457.2	89,083.9	28,373.3	75.8
12	Татварын бус орлого	1,549,679.3	1,491,217.2	58,462.1	96.2
120	Нийтлэг татварын бус орлого	164,092.9	105,630.8	58,462.1	64.4
122	Тусламжийн орлого	764,426.4	764,426.4	0.0	100.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	621,160.0	621,160.0	0.0	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,828,903.5	2,534,575.0	294,328.5	89.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,098,218.6	1,920,178.7	178,039.9	91.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,067,096.2	1,893,216.2	173,880.0	91.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	947,301.9	932,716.9	14,585.0	98.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,011.5	124,834.9	2,176.6	98.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	572,558.2	525,113.1	47,445.1	91.7

2104	Хангамж, бараа материалын зардал	36,894.6	26,414.3	10,480.3	71.6
2105	Нормативт зардал	1,977.1	264.0	1,713.1	13.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103,971.5	93,326.8	10,644.7	89.8
2107	Томилолт, зочны зардал	11,491.2	7,515.2	3,976.0	65.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	207,497.1	137,492.7	70,004.4	66.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,393.1	45,538.5	12,854.6	78.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,122.4	26,962.5	3,159.9	89.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	730,684.9	614,396.3	116,288.6	84.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	230,000.0	0.0	230,000.0	0.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(120,024.9)	63,950.5	(183,975.4)	(53.3)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	120,024.9	(63,950.5)	183,975.4	(53.3)
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	120,024.9	(63,950.5)	183,975.4	(53.3)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	463,124.9	(463,124.9)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	525,502.7	(525,502.7)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	58	58	0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28	28	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	28	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант оны гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	47,221.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,221.8
122	Тусламжийн орлого	47,221.8
1221	Хандив тусламж /дотоод/	47,221.8
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,221.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,772.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,772.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,772.4
2104	Хангамж, бараа материалын зардал	31,858.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,484.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,430.0
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	6,449.4
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(6,449.4)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(6,449.4)

Б.Болорцэцэг нарт **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.



4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **34,799.3** мянган төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруулсан. Үүнд:

ИТХ:

- Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдаж авсан зардлын тохируулгыг 1,632.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,

ЗДТГ:

- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 2,209.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,

ТТЗ:

- Санхүүгийн байдлын тайланд татаас санхүүжилтийн авлага, өглөг болон тэдгээрт хамаарах устгалыг 6,752.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг 24,204.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 1-р хавсралтаар баталсан “Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын 2.3, 2.4(б) дэх заалтууд болон “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт **144,585.8** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 144,585.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага, сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **144,585.8** мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **123,357.6** мянган төгрөгөөр их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, хөтөлбөр, зориулалт, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **10,909.3** мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

ИТХ:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 450.0 мянган төгрөгийн Си Ти Эс программын төлбөр, 393.0 мянган төгрөгийн бараа материалын зардал, 675.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн засвар, 324.0 мянган төгрөгийн хуралдааны зардал зэрэг нийт **1,842.0** мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас 220.0 мянган төгрөгийн ус цэвэршүүлэгч, урсгал засварын материалын зардалд 519.0 мянган төгрөг, 55.6 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал зэрэг **794.6** мянган төгрөг гэх мэт.

ЗДТГ:

- Цалингийн ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас даатгуулагчаас төлөх НДШ-ийн зардалд **2,147.7** мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 5,000.0 мянган төгрөгийн торгуулийн төлбөр төлсөн, 450.0 мянган төгрөгийн Си Ти Эс программын төлбөр төлсөн зэрэг нийт **5,450.0** мянган төгрөг.
- Бараа үйлчилгээний бусад зардлаас **675.0** мянган төгрөгийн төрийн далбаа худалдаж авсан гэх мэт.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

2. Орон нутгийн төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөөг **132,719.5** мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.



3. Тайлант онд ЗДНХ-өөс гадаад паспортын төхөөрөмж худалдан авах зардалд **957.0** мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1 дэх “Нөөц хөрөнгийг зарцуулах тухай Засаг даргын шийдвэрийн төсөл нь дор дурдсан шаардлагыг хангасан байна. 3.1.2: “.....энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр батлагдсан төсвийг зориулалт бусаар, хөтөлбөр, зориулалт, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг арилгалгүй, давтан гаргасан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал” болон Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэсэн заалтын дагуу ИТХ-ын нарийн бичгийн дарга Т.Уянга, ЗДТГ-ын дарга Ү.Янжиндулам, төсвийн ерөнхий нягтлан бодогч Э.Цэнд-Аюуш, нягтлан бодогч Б.Болорцэцэг нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2 Зөвлөмж

5.2.1. Нэмэлт санхүүжилтийн данстай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрч буй өвс, тэжээлийн тооцоог данс бүртгэлээр дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, УСНББОУС-12 “Бараа материал”-ын 11 дэх “бараа материал нь худалдан авсан болон буцаан борлуулахаар эзэмшиж байгаа барааг өөртөө

агуулдаг” гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.


1.2. Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг үндэслэн бараа материалын орлого, зарлагыг тухай бүр санхүүгийн программд бичилт хийж байх.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ



Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ИТХ	1	1,632.0			1	1,632.0	1	1,632.0				
ЗДТГ	1	2,209.9			1	2,209.9	1	2,209.9				
ТТЗ	2	30,957.4			2	30,957.4	2	30,957.4				
Дүн	4	34,799.3			4	34,799.3	4	34,799.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	2	8,272.7			1	8,272.7	1					
ТТЗ	4	133,676.5			2	133,676.5			2	2		
ТТЗ-ийн Дүн	9	144,585.8			4	144,585.8	1		4	4		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Төсвийн хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулсан	1	2,870.0			1	2,870.0		
Дүн	1	2,870.0			1	2,870.0		
Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилт								
Төсөл, арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолт зэргийг урьдчилан хийлгүйгээр, ИТХ-аар батлуулсны дараа гүйцэтгүүлсэн	1	44,840.0			1	44,840.0		
Дүн	1	44,840.0			1	44,840.0		
Нийт дүн	2	47,710.0			2	47,710.0		